



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 6 сарын 11 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### XXIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXIII хурал 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 10:00 цагт Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга **Ө.Энхтувшин** даргалав.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын нөхцөл байдлын мэдээ болон гадаад улс орнуудаас иргэдээ татан авахтай холбогдуулан ХӨСҮТ-ийн бэлтгэл, бэлэн байдлын талаар;

*Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал  
Д.Нямхүү*

2. Хилийн боомтуудын талаарх нөхцөл байдлын мэдээ;

*МХЕГ-ын дэд дарга  
Г.Сүгэрбат*

3. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэхэд зориулж Монгол Улсын Засгийн газраас АНУ-д үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн ажлыг зохион байгуулах талаар;

*Гадаад харилцааны яамны  
ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
О.Энхцэцэг*

4. Гадаад улс орнуудаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг зохион байгуулалттайгаар татан авах тухай;

*Консулын газрын захирал  
П.Мөнхтүшиг*

5. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэхэд үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдыг түрээсийн орон сууцанд хамруулах талаар;

*Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч  
Ж.Батбаясгалан*

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Улсын онцгой комиссоос мэдэгдэл гаргахаар тогтов.

Б. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд” гэдэгт БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонгконг, Макаог хамруулж зохих арга хэмжээ авч ажиллахаар тус тус тогтов;

Нэг. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал нарт:

1.1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас хүмүүнлэгийн тусlamжаар олгосон болон улсын нөөцөд бүрдүүлсэн “N95” загварын амны хаалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд олгох, шаардлагатай нэмэлт нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх;

Хоёр. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар,

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Дорнод аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга М.Бадамсүрэн,

Сүхбаатар аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Ж.Эрдэнэбаатар,

Дорноговь аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Т.Энхтувшин,

Өмнөговь аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Н.Наранбаатар нарт:

2.1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, БНХАУ-ын талтай тохиролцох, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Дорноговь аймгийн Ханги хилийн боомтоор ачаа тээврийн хэрэгслийн урсгалыг

зохих журмын дагуу нэмэгдүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

Гурав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нарт:

3.1. “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах хяналт, шалгалтаас бусад чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад хийгдэж буй элдэв дарамт шахалт үзүүлсэн төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг зогсоож, бизнес эрхлэлтийг дэмжих, тэдэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах, хяналт шалгалтыг нэгдсэн зохицуулалтад оруулах;

Дөрөв. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайханд:

4.1. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдад түрээслэн өмчлүүлэх хэлбэрээр орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд чанар, стандартын шаардлага хангасан орон сууцаар хангах ажлыг үе шаттай, шуурхай, үр дүнтэй зохион байгуулах;

Тав. Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,

Тагнуулын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Д.Гэрэл,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт нарт:

5.1. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдад орон сууцны хуваарилалт /квот/-ын дагуу байгууллага дотроо хамт олны саналаар сонгон шалгаруулалт хийж, Улсын онцгой комисст саналаа танилцуулах, түрээслэн өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

Зургаа. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн бригадын генерал Ж.Бямбасурэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхувь,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Дорнод аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга М.Бадамсурэн,

Сүхбаатар аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Ж.Эрдэнэбаатар,

Дорноговь аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Т.Энхтувшин,

Өмнөговь аймгийн Засаг дарга бөгөөд

Аймгийн онцгой комиссын дарга Н.Наранбаатар нарт:

6.1. Улсын хилээр нэвтрэх экспорт, импортын ачаа, барааг зохих журмын дагуу хүндрэл, чирэгдэлгүйгээр нэвтрүүлэхэд анхаарч ажиллах;

6.2. Ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах зорилгоор олон улсын ачаа, барааг Монгол Улсын хилээр нэвтрүүлсний дараа тухайн хилийн бүс орчмоос төмөр замын тээврээр тээвэрлэх боломжийг судлах;

Долоо. Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн бригадын генерал С.Баатаржавт:

7.1. Олон улсын ачаа тээврийн хамгаалалт, хяналтад үүрэг гүйцэтгэж буй Цагдаагийн байгууллагын автомашин замын нөхцлөөс хамааран эвдрэл, гэмтэл үүсч, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангахад хүндрэл учирч байгаа тул тээвэрлэлтийн хэвийн нөхцлийг хангах, бусад байгууллагаас дэмжлэг авах саналаа Улсын онцгой комисст танилцуулж, шийдвэрлүүлэх;

Найм. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг,

Улсын онцгой комиссын гишүүдэд:

8.1. Улсын хэмжээний бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор гадаадын ажиллах хүчнийг үе шаттай, зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх, холбогдох зохицуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

8.2. Сангийн яамны харьяа “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгжийн Замын-Үүд боомт дахь төслийн ажилчдын байранд улсын хэмжээний бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрт гадаад улсаас ирж ажиллах инженер, техникийн ажилчдыг түр байршуулан Коронавируст халдварт /КОВИД-19/-ын шинжилгээ авах зорилгоор ашиглах асуудлыг БНХАУ-ын талтай дипломат шугамаар зөвшилцэх;

Ес. Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Д.Ганзориг нарт:

9.1. Цэргийн мэргэжлийн уралдаан, тэмцээн, олон улсын хамтарсан хээрийн сургуулийг зохион байгуулах, оролцуулах эсэх талаар саналаа боловсруулж, Улсын онцгой комисст танилцуулж, шийдвэрлүүлэх;

Арав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал нарт:

10.1. Гадаад улсаас ирсэн иргэдийг хилийн боомт, төмөр замын өртөө, зөрлөг, нисэх онгоцны буудлаас эмнэлэг, тусгаарлах байр хүртэл, тусгаарлах байрнаас хот, суурин газар хүртэл авто болон төмөр замаар тээвэрлэсэн тээвэрлэлтийн зардлыг тээврийн хэрэгслийн төрөл, ангиллаас хамааран 1 хүн/км-ийн жишигт нийцүүлэн тооцсон тээврийн байгууллагын саналыг үндэслэн Улсын онцгой комиссоос баталсан тарифын дагуу иргэнээр төлүүлэх;

10.2. Улсын авто болон төмөр замын хилээр нэвтрүүлж байгаа ачаа, вагон, чингэлэг, тээврийн хэрэгслийн гадаргууд хийх ариутгал, халдвартгуйжүүлэлтийн төлбөрийг Монгол Улсын Сангийн сайдын “Хэмжилт, шинжилгээ, халдвартгуйжүүлэлтийн үнийг батлах тухай” 2018 оны 253 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан жишиг үнийн дагуу тооцож, тээвэрлүүлэгчээс гаргуулах;

ДАРГА,  
ШАДАР САЙД

Ө.ЭНХТУВШИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САНЖАА